

БНМАУ-ЫН СОЁЛЫН ЯАМНЫ КОЛЛЕГИ, УЛААНБААТАР
ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ГИШҮҮДИЙН
ХҮРТЫН ТОГТООЛ.

1979 оны 12 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 27/327

Улаанбаатар
хот

НОМЫН САН, НОМЫН ДЭЛГҮҮР НЭЭЖ
АЖИЛДУУЛАХ ТУХАЙ

ЗХУ-ын техник-эдийн засгийн тусламжтайгаар 5 дугаар хороололд баригдсан нийтийн номын сан, номын худалдааны дэлгүүрийн барилгыг хүлээн авах зорилгоор БНМАУ-ын Соёлын яамны коллеги, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НЬ:

1. ЗХУ-ын техник-эдийн засгийн тусламжтайгаар баригдсан 300,0 мянган номын багтаамжтай номын санд Улаанбаатар хотын төв номын санг нээж хотын соёлын хэлтэст, 4 худалдагчтай номын дэлгүүрийг Зөвлөлтийн номын дэлгүүр болгож, Улсын номын худалдааны газарт тус тус харьяандуулсугай.

2. Улаанбаатар хотын төв номын сангийн номын фондыг Улсын нийтийн номын сан, хотын бусад номын сангийн номын фондыг шилжүүлэн зохицуулах, шинээр худалдаж авах замаар бүрдүүлэх арга хэмжээг Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны соёлын хэлтэс /н.ШАГШАР/-т үүрэг болгосугай.

3. Улаанбаатар хотын төв номын сан, номын дэлгүүрийн захиргааны орон тоог 1979 оны 12 дугаар сарын 20-ноос эхлэн ажилдуулж, шинээр ажиллах орон тоог боловсруулан ХХКУ-ын хороонд оруула бэлдүүлэхийг Соёлын яам /н.БОРХОНШОЙ/, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.ЦЭНН/ нарт даалгасугай.

2.

4. Дээрх номын санг мэргэжлийн боловсон хүчнээр хянахыг Соёлын яамны боловсон хүчин, захиргааны хэлтэс /н.НАНЗАЦ/-г үүрэг болгосугай.

5. Номын сан, номын цэцгүүрийн үйлчилгээг Улаанбаатар хотын төв номын санд хариуцуула, номын цэцгүүрийн берилга бэйгууламжийг Удсын номын худалдааны газарт ашигтуулаугай.

6. Улаанбаатар хотын төв номын сан шинээр бэйгуулагдсантай холбогцуула А.Н.Горькийн нэрэмжит наацугээр номын санг Улаанбаатар хотын А.Н.Горькийн нэрэмжит күүхэд залуучуудын төв номын сан болгон, одоо ажиллаа байгаа хүүхдийн номын санг түүний салбар номын сан болгосугай.

7. Хотын нийтийн номын сангуудын эрх арга зүйн удирдлагыг Улаанбаатар хотын төв номын санд төвлөрүүлэх асуудал боловсруула 1980 оны I дүгээр улиралд Соёлын яам, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны оруулахыг Соёлын яамны соёл-гэгээрлийн хэлтэс /н.ЭНХ-ОЧИР/, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны соёлын хэлтэс /н.ЛАГШАР/-г үүрэг болгосугай.




Э.Д.Орзуурэн
 /Э.Д.ОРЗУУРЭН/

С.Энхсарал
 /С.ЭНХСАР АЛ/